



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/258

Хэрлэн сум

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2, 11.1.7 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг даргын нэрэмжит эрүүл мэндийн салбарын шилдэг сувилагч шалгаруулах журмыг хавсралтаар баталсугай.

2.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны  
дугаар сарын 25-ны өдрийн  
дугаар захирамжийн хавсралт

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ШИЛДЭГ СУВИЛАГЧ  
ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Ерөнхий үндэслэл:

1.1. Энэхүү журам нь Эрүүл мэндийн тухай бэгц хууль, “Алсын хараа-2050” бодлогыг хэрэгжүүлэх эрүүл мэндийн байгууллагуудын сувилагч нарын ажлын бүтээмжийг дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг дэмжих, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж, чадамжийг хөгжүүлэх, ажлын хариуцлагыг нэмэгдүүлэн, эмчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэгдэнэ.

1.2. Аймгийн Засаг даргын нэрэмжит шагналаар шагнуулах сувилагч нарыг шалгаруулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.3. Аймгийн Засаг даргын нэрэмжит шагналаар шагнуулах сувилагч нарын шалгаруулалтад байгууллагаас нэр дэвшихдээ дараах ерөнхий шаардлагыг хангасан байна.

1.3.1. Тухайн байгууллагын үндсэн орон тооны албан хаагч байна.

1.3.2. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацаа хүчинтэй байх, сувилах эрхийн зөвшөөрөлтэй сувилагч байх

1.3.3. Кредит багц цагийн бүрдэлт хангасан байх

1.3.4. Мэргэжлийн алдаа зөрчил гаргаагүй байх

1.3.5. Тухайн жилдээ эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, харилцаа хандлагын зөрчилгүй гаргаагүй байх

2. Тусгай шаардлага:

Шалгаруулалт зарласан өдрөөс хойш 14 хоногийн хугацаанд дараах ажлыг хэрэгжүүлсэн байна.

2.1. Сувилахуйн 5 шатлалыг стандартын дагуу (Эрүүл мэндийн сайдын 2015 оны 497 дугаар тушаал, MNS 4621:2008 сувилахуйн түгээмэл үйлдлийн стандарт) хэрэгжүүлэн, бодит үр дүн гарсан байх

2.2. Үйлчлүүлэгчид сувилахуйн оношийг үндэслэн зөвлөгөөг өгч ажилласан байдал.

2.3. Иргэдэд сувилахуйн асаргаа сувилгааны чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулах

2.4. Шинэ санаа, оновчтой бүтээлийг нэвтрүүлсэн байх

3. Шалгаруулалтын материал хүлээн авах

3.1. Салбарын хэмжээнд шилдэг сувилагч шалгаруулах ажлыг нээлттэйгээр зохион байгуулж, аливаа маргаан гомдол санал үүсэхээс сэргийлж ажиллана.

3.2. Эрүүл мэндийн байгууллага бүр бүх сувилагч нарын оролцоог ханган, шилдэг сувилагчид нэр дэвшүүлэх материалыг жил бүрийн 05 сарын 01-ний дотор Эрүүл мэндийн газарт ирүүлэхэд дэмжлэг үзүүлж, удирдлагаар ханган ажиллана.

3.3. Материалыг файл хэлбэрээр ер системээр дамжуулан хүлээж авна.

3.4. Шалгаруулалтад ирүүлэх материал:

3.4.1. Үндсэн орон тооны албан хаагч гэдгийг тодорхойлсон байгууллагын албан бичиг

3.4.2. Эцэслэн шийдвэрлэгдсэн асуудлаар ямар нэгэн мэргэжлийн болон ёс зүйн алдаа гаргаагүйг нотлох байгууллагын тодорхой толт.

3.4.3. Лицензийн хуулбар

3.4.4. Сувилахуйн тусламж үйлчилгээний чиглэлээр багц цагийн сургалтад хамрагдсаныг нотлох бичиг, баримт

3.4.5. Ёс зүйн сургалтад хамрагдсан баримт

3.4.6. Сувилахуйн 5 шатлалыг стандартын дагуу хөтөлсөн баримт, бодит үр дүнг гарсан жишээг баримтжуулан ирүүлэх

3.4.8. Үйлчлүүлэгчид сувилахуйн оношийг үндэслэн зөвлөгөөг өгч ажилласан тайлан. Тайланд өгсөн зөвлөгөөнүүдийн агуулга, гарсан бодит үр дүн, өөрчлөлт болон холбогдох зургийг хавсаргасан байна.

3.4.9. Иргэдэд сувилахуйн асаргаа сувилгааны чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулсан тайлан, зураг, видео бичлэг, ашигласан хэрэглэгдэхүүн болон холбогдох материалуудыг эх хувиар хавсаргах

3.4.10. 2-с доошгүй шинэ санаа, оновчтой бүтээлийг нэвтрүүлж хэрэгжүүлснийг нотлох баримт

4. Шалгаруулалтыг зохион байгуулах үе шат:

1-р шатны шалгаруулалт: Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг холбогдох материалтай танилцаж, 100 хүртэлх хувиар үнэлэн 85-с доошгүй үнэлэгдсэн сувилагч нарыг шалгаруулна.

2-р шатны шалгаруулалт: Шаардлага хангасан оролцогчдын хийсэн ажлыг 5 хоногийн хугацаанд олон нийтийн хэвлэл мэдээллийг хэрэгсэл, Эрүүл мэндийн газар, аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудсаар дамжуулан иргэдэд танилцуулж, хамгийн өндөр санал, хандалтыг авсан эхний 5 оролцогчид эхний шалгаруулалтын дүн дээр нэмэлт оноо өгнө.

- Сувилагч нар өөрсдөө олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулах мэдээлэл, бичлэгийг бэлтгэж Эрүүл мэндийн газарт хүргүүлж ажиллана.

- Шалгарсан сувилагч нарт 3 дахь шатны сонгон шалгаруулалтад оролцох "ЭРХИЙН БИЧИГ"-ийг сувилагч нарын баярын өдрийн үйл ажиллагаа дээр гардуулна.

3-р шатны шалгаруулалт:

Сувилахуйн тусламж үйлчилгээний "MNS 4621:2008" түгээмэл үйлдлийн стандартыг технологийн дагуу гүйцэтгэх ур чадварын тэмцээнийг зохион байгуулж, шилдэг 20 хүртэлх оролцогчдыг шалгаруулна.

- Ур чадварын тэмцээний удирдамж, бэлтгэх чиглэлийг оролцогч нарт хүргүүлсэн байна.

- Өгөгдсөн кейс, тохиолдол дээр ажиллах ур чадвар

- Харилцааны чадвар (Ярих, бичих, товч тодорхой танилцуулах ур чадвар гэсэн 4 үзүүлэлтээр дүгнэнэ)

- Дээрх үзүүлэлтүүдийг 100 хүртэлх хувиар үнэлнэ.

- Шүүгч нарын бүрэлдэхүүнд Сувилахуйн сургууль, нийгэмлэг болон ТББ-ын төлөөллийг оролцуулна.

Эхний 3 шатны шалгаруулалтын дүнг нэгтгэн 5 дугаар сард багтаан аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, шагнал олгох шийдвэрийг гаргана.

5. Шагнал, урамшуулал: Сувилагч нарын нийгмийн баталгааг хангахад зориулж шалгаруулалтын үе шатуудад цуглуулсан хувиар хамгийн өндөр хувь авсан 1 сувилагчийг 25 сая төгрөг, дэд байр эзэлсэн 1 сувилагчийг 10 сая төгрөг, 3 дугаар байр эзэлсэн 1 сувилагчид 5 сая төгрөгийн мөнгөн дэмжлэг тус тус үзүүлнэ.

Шилдэг 20 сувилагчид шалгарч 3 шатны шалгаруулалтад оролцсон шагналт байранд ороогүй сувилагч бүрт 500.000 мянган төгрөгийн урамшуулал олгоно.

6. Хүлээгдэж буй үр дүн:

- Сувилагч нар тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөл бүрдэнэ.

- Сувилагчийн бие даасан байдал, мэргэжлийн үнэ, цэнэ дээшилнэ.

- Сувилагчийн нийгмийн асуудал шийдвэрлэгдэнэ.

- Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж дээшилнэ.

7. Үйл ажиллагааг сурталчлах: Сүүлийн шатанд шалгарсан сувилагчийн "Сувилагчийн үнэ цэнэ" нэвтрүүлэг хийж, олон нийтэд, түгээнэ.

8. Шагнал гардуулах: Шагналыг 8 дугаар сарын 13-ны өдөр болох Эрүүл мэндийн ажилтын өдрөөр гардуулна.